



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/67

Улаанбаатар хот

### 「Стандартын үзлэг зохион байгуулах тухай」

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, нийслэлийн Засаг даргын “Үзлэг, шалгалт хийх тухай” 2017 оны А/628 дугаар захирамж, газрын Дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа амралтын газар, жуулчны бааз, гэр буудлуудад стандартын үзлэг, шалгалтад хамруулах ажилд тус газрын мэргэжилтнүүдийг оролцуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Захиргааны хэлтсийн дарга /Д.Ганболд/-д даалгасугай.

2. Стандартын үзлэг зохион байгуулахад шаардагдах 3.161.050 /гурван сая нэг зуун жаран нэг мянга тавь/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА *D. Batm* Д.БАТСҮХ



1150590259

Нийслэлийн Засаг даргын 2017 оны  
08 дугаар сарын 25-ний өдрийн А/628  
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



УЛААНБААТАР ХОТЫН НУТАГ ДЭВСГЭРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ  
БАЙГАА АМРАЛТЫН ГАЗАР, ЖУУЛЧНЫ БААЗЫГ ШАЛГАХАД ШААРДАГДАХ  
ТЭЭВРИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ

2017 оны 08 дугаар сарын 15

Улаанбаатар хот

№	Дүүрэг явах чиглэл	Шатахууны нийт зардал	Машины түрээс 1 өдөр	Түрээсийн нийт зардал	Нийт зардал
1	Налайх Горхи тэрэлж /1-р баг/	66.900	Нийслэлийн Авто баазаас	старекс	66.900
2	Налайх Горхи тэрэлж /2-р баг/	57.900	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас	старекс	57.900
3	Чингэлтэй	24.750	150.000	300.000	324.750
4	Сүхбаатар	24.750	150.000	300.000	324.750
5	Хан-уул	24.750	150.000	300.000	324.750
6	Баянзүрх	99.500	150.000	450.000	499.500
7	Багануур	99.000	Нийслэлийн Мэргэжлийн газраас	старекс	99.000
8	Сонгинохайрхан	49.500	300.000	450.000	349.500
	Бүгд				<b>2.041.050</b>
<b>Ажлын хэсгийн хоолны зардлын төсөв</b>					
№	ажиллах хүмүүсийн тоо	Нэг хүний өдрийн хоолны зардал 10.000 төг		Нийт зардал	
1	56 хүн	2 өдөр* 20.000		<b>1.120.000</b>	
<b>НИЙТ ТӨСӨВ</b>				<b>3.161.050</b>	

ТӨСӨВ ЗОХИОСОН:  
НАЖГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

М.БААСАНДОРЖ

ХЯНАСАН:  
НЗДТГ-ЫН САНХҮҮ ТӨРИЙН  
САНГИЙН ХЭЛТСИЙН ТӨСВИЙН  
ЕРӨНХИЙ МЭРГЭЖИЛТЭН

Б.ТӨГСЛХАМ